

БАТЛАВ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Тендер шалгаруулалтын код: БНХК/20240103106

Тендер шалгаруулалтын нэр: Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг

Байршил: "Багануур" ХК-ийн ажлын байранд хийвэл давуу тал болно. Зайлшгүй шаардлагатай нөхцөлд тухайн эмнэлгийн байгууллага дээр үзлэг шинжилгээ хийлгэж болно.

Үргэлжлэх хугацаа: 2024 оны 05 дүгээр сарын 01-нээс 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл

Хамрах хүрээ: "Багануур" ХК-ийн хөдөлмөрийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд ажилладаг 1180 ажилтныг хамруулна. /Шаардлагатай тохиолдолд нэмэгдэж, хасагдаж болно./

1. Хийгдэх үзлэг шинжилгээний төрлүүдийг доор хүснэгтээр харууллаа.

№	Үзлэг хийх нарийн мэргэжлийн эмч нар, шинжилгээний төрөл		
1	Зүрх судас		
2	Дотор /Элэг цөс, Бөөр шээс ялгаруулах тогтолцоо гэж задарч болно/		
3	Нүд /Нүдний уг дурандах/		
4	Багажийн шинжилгээ	Зүрхний цахилгаан бичлэг	
5		Зүрхний ЭХО	
6		Холтер, Титэм судасны КТГ, ачаалалтай сорил, /шаардлагатай тохиолдолд /	
7		Хэвлийн ЭХО	
8		Цээжний рентген зураг /флюор	
9		Алат	
10		Элэг, цөс, нойр булчирхайн үйл ажиллагаа	Асат
11		Гаммаглютамилтрансфераза	
12	Нийт билирубин		
13	Шүлтлэг фосфатаза		
14	Амилаза, липаза		
15	Холестрин		
16	Триглицерид		

17	Өөх тос, нүүрс усны солилцоо	Сахар /шаардлагатай тохиолдолд 3 сарын дундаж сахар/
18		Бага нягтралтай өөх тос
19		Их нягтралтай өөх тос
20	Иммунологийн шинжилгээ	ASLO, CRB, RF,
21		Тропонин, зүрхний дутагдал илрүүлэх шинжилгээ /шаардлагатай тохиолдолд/
22	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	
23	Шээсний ерөнхий шинжилгээ	

Зайлшгүй шаардлагатай тохиолдолд тохиромжтой хувилбараар бага зэрэг өөрчлөлт оруулах санал гаргаж зөвшилцөлд хүрч болно.

2. Ажил үйлчилгээ гүйцэтгэх байгууллагад тавигдах шаардлага:

2.1 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийх итгэмжлэл бүхий төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, лабораторитай байна.

2.2 Үзлэг хийх эмч нарын багт: Мэргэжлийн өндөр зэрэгтэй зүрх судасны, дотор /хоол боловсруулах, бөөр гэж задарч болно/ нүдний гэсэн нарийн мэргэжлийн ур чадвар сайтай, мэргэшлийн зэрэг цол бүхий эмч нар байна.

2.3 Ачаалалтай ажиллах чадвартай, илүү цагаар ажиллах тохиолдолд илүү цагийн хөлсийг тухайн эмнэлгийн байгууллага өөрсдөө хариуцах, хоол болон эмч нарын байрлах буудлын хөлсийг тухайн эмнэлгийн байгууллага хариуцна.

2.4 Багажийн болон лаборатори шинжилгээ хийх аппарат тоног төхөөрөмж нь стандарт чанар аюулгүй байдал хангасан, сүүлийн үеийн, өндөр үзүүлэлттэй байна.

3. Ажлын тайлагнал:


3.1 Ажлыг гүйцэтгэх явцад захиалагч "Багануур" ХК-ийн нууцад хамаарахаас бусад шаардлагатай мэдээллээр хангана.

3.2 Үзлэгийн төгсгөлд ажилтан бүрийн үзлэгийн ерөнхий дүгнэлтийг бичиж нарын үсэг зурж тамга тэмдэг дарсан байх ба компанийн хэмжээнд тохиолдож байгаа өвчлөл, өвчлөлийг хэрхэн бууруулах талаар зөвлөмж дүгнэлт гарган, танилцуулгыг word, powerpoint/ компанийн удирдлагын баг болон ажилтнуудад тайлагнана.

3.3 Ажлын дүгнэлт тайланг цаасан болон цахим хэлбэрээр компанид үлээлгэж өгнө.

БОЛОВСРУУЛСАН:

ҮЙЛДВЭРИЙН ЭМЧ



Д.ТҮВШИНБАЯРМАА

ХЯНАСАН:

ХАБЭАХ-ИЙН ДАРГА



Ч.АРИУНБААТАР